



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2021 он

АГУУЛГА

Танилцуулга, бүтэц зохион байгуулалт..... Хуудас 2-3

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- ✓ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын 2020 онд хамтран ажиллах гэрээний биелэлт.....Хуудас 4-5

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- ✓ Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- ✓ Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт..... Хуудас 5-6

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

- ✓ Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт
- ✓ Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр:
- ✓ Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн мэдээлэл
- ✓ Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
- ✓ Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа
- ✓ “Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ.....Хуудас 6-41

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- ✓ Нийслэлийн аялал жуулчлалын газрын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн тайлан.....Хуудас 42-45

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

- ✓ Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр
- ✓ Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажил
- ✓ Шинээр санаачилсан ажлууд
- ✓ Үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт..... Хуудас 45-47

“ТАНИЛЦУУЛГА”

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоолоор нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар байгуулагдан, нийслэлийн Засаг даргын 2009 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дүгээр захирамжаар тус газрын бүтэц орон тоог 12 хүнтэй үүнээс дарга -1 байхаар баталж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2009 оны 01 дүгээр тушаалаар ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-9 албан хаагчтай анх үйл ажиллагаагаа эхэлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” А/323 дугаар захирамжаар тус газрын бүтэц орон тоог нэмэгдүүлэн шинэчилж 18, үүнээс дарга 1 байхаар баталж, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-12 /ТЗ/, мэдээллийн төвийн менежер-1, мэдээллийн технологи хариуцсан инженер-1, архив, бичиг хэргийн эрхлэгч-1 /ТҮ/ албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны “Дүрэм батлах тухай” А/831 дүгээр захирамжаар тус газрын дүрмийг шинэчлэн баталж, газрын дарга-1, орлогч дарга-1, Захиргааны хэлтэс-6, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс-5, Мэдээлэл, сурталчилгааны хэлтэстэй-5 буюу үндсэн ажилтан 18, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай” А/283 дугаар захирамжийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр мэдээлэл, сурталчилгааны төвийн ажилтан-3, нийт 21 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн удирдлага, дэмжлэгээр хангах, нийслэл хотыг гадаад дотоодод сурталчлах, төрөөс аялал жуулчлалын чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав.

Байгууллагын үйл ажиллагааны 2021 оны жилийн үйл ажиллагааны тайланг нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу нэгтгэж тайлагнав.

✓ **АЛСЫН ХАРАА:**

Аялал жуулчлалыг нийслэл хотын эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилд шийдвэрлэх үүрэг бүхий салбар болгон хөгжүүлнэ.

✓ **ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Нийслэл Улаанбаатар хотыг гадаадын жуулчин хүлээн авах хүчин чадал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий хот болгон хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

✓ **ХАМРАХ ХҮРЭЭ:**

Нийслэлийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчид, аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагууд.

✓ **ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД:**

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сайжруулах, шинээр бий болгох

2. Жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, жуулчны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах


3. Улаанбаатар хотын гадаад сурталчилгааг явуулж, зорих газрын менежментийн бодлого, маркетингийн стратегийг хэрэгжүүлэх

4. Жуулчдыг татах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлалын эдийн засаг, нийгмийн нөлөөллийг зохистой хэмжээнд байлгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах

5. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх

6. Жуулчид, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад зориулсан төрөл бүрийн сургалт, судалгааны ажлууд зохион байгуулах
7. Нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нэг. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тус газраас хэрэгжүүлэхээр 3 зорилтын 3 арга хэмжээ тусгагдсан.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 90.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилт		
Нийт арга хэмжээний тоо		3
1. Бүрэн хэрэгжсэн	100	2
2. Үр дүн гарсан	90	
3. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70	1
4. Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн	50	
5. Боловсруулалтын шатанд	30	
6. Бэлтгэл ажлыг хангаж байгаа /ажил зохион байгуулаагүй/	0	
Хэрэгжилтийн хувь		90.0 хувь

Хоёр. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/115 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тус газраас хэрэгжүүлэхээр нийт 6 зорилтын 12 арга хэмжээ тусгагдсан.

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 92.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт		
Нийт арга хэмжээний тоо		12
1. Бүрэн хэрэгжсэн	100	9
2. Үр дүн гарсан	90	
3. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70	3
4. Ажил эхэлсэн	50	
5. Боловсруулалтын шатанд	30	
6. Бэлтгэл ажлыг хангаж байгаа /ажил зохион байгуулаагүй/	0	
Хэрэгжилтийн хувь		92.5 хувь

Гурав. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын хамтран ажиллах гэрээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2021-2024 онд хамтран ажиллах гэрээгээр 2021 онд аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр нийт 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Хамтран ажиллах гэрээний хэрэгжилт 3 дугаар улирлын байдлаар 78.0 хувьтай биелсэн байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт		
Нийт арга хэмжээний тоо		10
1. Үр дүн гарсан	90	6
2. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70	3
3. Ажил эхэлсэн	50	
4. Боловсруулалтын шатанд	30	1
5. Бэлтгэл ажлыг хангаж байгаа / ажил зохион байгуулаагүй	0	
Хэрэгжилтийн хувь		78.0 Хувь

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

А.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд тайлант хугацаанд 4 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 25 зүйл, заалтын хэрэгжилтийг дүгнэхэд, гүйцэтгэл 98.8 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” үр дүнтэй байна.

Төрлөөр нь авч үзвэл:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төрөл	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн /90-100/	Хэрэгжих шатандаа /50-89/	Хэрэгжилт хангалтгүй /10-49/	Хэрэгжээгүй /0-9/	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн дундаж
Монгол Улсын хууль	2	15	15					100%
Монгол Улсын Засгийн газрын тогтоол	1	9	9					100%
Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	1	1		1				70%
НИЙТ	4	25	24	1				98.8%

Б. Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд.

Байгууллагын хэмжээнд 2021 оны байдлаар 35 захирамжлалын баримт бичгийн нийт 48 заалт үүрэг, даалгавраас бүрэн хэрэгжсэн 46, хэрэгжих шатандаа 2 буюу 98.75 хувийн биелэлттэй гарч, хугацаанд нь тухай бүр www.Monitoriq.ulaanbaatar.mn програмд тайлагнасан.

Төрлөөр нь авч үзвэл:


Захирамжлалын баримт бичгийн төрөл	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн /90-100/	Хэрэгжих шатандаа /50-89/	Хэрэгжилт хангалтгүй /10-49/	Хэрэгжээгүй /0-9/	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн дундаж
Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоол	1	1		1				70%
Нийслэлийн Засаг даргын захирамж	27	29	28	1				97.5%
Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл	6	16	16					92.5%
Нийслэлийн Онцгой комиссыг хурлын тэмдэглэл	1	2	2					100%
НИЙТ	35	48	46	2				98.75

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

А. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ:

1. Аялал жуулчлалын байгууллага болон жуулчдад үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

"Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын хүрээнд E-Mongolia нэгдсэн системээр зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлт ирүүлсэн хүсэлтийн дагуу үзлэг шалгалт зохион байгуулж, стандартын шаардлага хангасан 254 зочид буудал, 133 дэн буудал, 76 амралтын газар, 11 жуулчны бааз нийт 474 газарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.



2. Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарын нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах ажлын хүрээнд:

Жуулчдад зориулсан эвент, арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр:

- Улаанбаатар хотноо 2021 онд зохион байгуулагдах 13 эвент арга хэмжээ, 2022 онд зохион байгуулагдах 15 эвент арга хэмжээний хуваарийг гаргаж Газрын цахим хуудас, Youtube хуудсанд байршуулж олон нийтэд сурталчилсан. Үүнд: “Улаанбаатарын өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Улаанбаатар” Аялал жуулчлалын үзэсгэлэн, “Талын салхи” Олон улсын мото наадам, “Playtime music festival”, “Дээлтэй Монгол наадам”, “Naadam night”, “Улаанбаатар” Үндэсний хоолны наадам, “Хуралдайн наадам-Шонхорын баяр”, “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль, “Улаанбаатар явган аяллын фестиваль” “Уухай” шагайн харвааны наадам, “Чингис хааны мэндэлсэн өдөр” хаадын чуулбар, “Солонгосын соёлын өдрүүд” наадам, Япон соёлын наадам

“Талын салхи” Олон улсын мото наадам

Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийслэлийн мотоцикл, мото спорт сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, түүгээр дамжуулан түүх соёл, ёс заншил, өв уламжлалаа олон нийтэд сурталчлах, залуусын эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, хөрш зэргэлдээ болон гуравдагч орнуудад эх орноо сурталчлах, жуулчдын сонирхлыг татах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагддаг “Талын салхи” Олон улсын мото наадам ковид-19 цар тахлаас шалтгаалан зохион байгуулагдаагүй бөгөөд “Талын салхи” Олон улсын мото наадмын тухай тухай зурагт хуудас, видео танилцуулга хийж, газрын цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр 18,490 хүнд сурталчилсан.



“Дээлтэй Монгол наадам”

Монголчуудын уламжлалт өв соёл, үндэсний хувцасны язгуур хэв шинж, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, дэлхий дахинд Монгол үндэстэн гэдгээ түгээн таниулах, үндэсний хувцсаараа дамжуулан үр хойчдоо түүх, соёл, уламжлалаа өвлүүлэн үлдээх зорилготой “Дээлтэй Монгол наадам”-ыг нийслэлийн Засаг даргын 2021 оны А/541 дүгээр захирамжийн хүрээнд 15 дахь зохион байгуулж, “Дээлтэй Монгол” бүжгийн уралдааныг 07 дугаар сарын 09-ний өдрөөс 1 сарын хугацаанд цахимаар зарлаж, уралдаанд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 20 аймаг, 6 улсаас нийт 5.000 гаруй оролцогч, 200 гаруй бичлэг ирүүлсэн бөгөөд шилдэг 10

оролцогчийг шалгаруулан “Дээлтэй өглөө” шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг Өглөөний гудамжинд зохион байгуулж 1,000 гаруй хүн үзэж сонирхон “Дээлтэй Монгол наадам”-ын нийт мэдээллийг телевиз, олон нийтийн сүлжээгээр 1,852,575 хүнд хүргэсэн.



1M

31 сэтгэгдэл 312 удаа хуваалцсан

Маш их таалагдлаа

Сэтгэгдэл

Хуваалцах

“Дээлтэй Монгол наадам”-ын хүрээнд “Монгол костюмс” ХХК, Цагдаагийн Ерөнхий газрын “Сүлд” чуулга, “Сэмүүн студи”-тэй хамтран Монголын 9 хаадын тамганы “Мөнх тэнгэрийн тамга” бүжгэн контентийг бүтээж, 3,000 гаруй хүнд үзсэн.



https://www.youtube.com/watch?v=i8u6_iM8lok

“Солонгосын долоо хоног” арга хэмжээ

Бүгд найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран “Солонгосын долоо хоног” арга хэмжээг цахимаар буюу “NTV” телевизийн “Эхнэрийн заавраар” нэвтрүүлгийн тусгай дугаарыг бэлтгэж, нэвтрүүлэгт урлаг, соёл, спортын олны танил хүмүүсийг гэр бүлийн хамт оролцуулан Солонгос үндэсний хоолыг хэрхэн хийх талаар нэвтрүүлэг бэлтгэн хүргэж, олон нийтийн сүлжээгээр 221, 000 хүн үзэж сонирхсон.



Embassy of the Republic of Korea in Mongolia 주몽골대한민국대사관

12 Nov · 🌐

Korea Weekly Special (Part 2) cooking program 'Ekhnerin zaavraar (My Wife Roll)' with the Embassy of the Republic of Korea Ju Hongol and NTV will be broadcast on NTV this week 11.13 (Sat) at 18:25 pm. We appreciate your interest.

⚙️ • Rate this translation



NTV ✓

10 Nov · 🌐

Эхнэрийн Заавраар ТУСГАЙ дугаар 2 - Солонгосын 7 хоног 🇰🇷 ... See more



Embassy of the Republic of Korea in Mongolia 주몽골대한민국대사관

12 Nov · 🌐

Korea Weekly Special (Part 2) cooking program 'Ekhnerin zaavraar (My Wife Roll)' with the Embassy of the Republic of Korea Ju Hongol and NTV will be broadcast on NTV this week 11.13 (Sat) at 18:25 pm. We appreciate your interest.

⚙️ • Rate this translation



NTV ✓

10 Nov · 🌐

Эхнэрийн Заавраар ТУСГАЙ дугаар 2 - Солонгосын 7 хоног 🇰🇷 ... See more



“Хийморь” олон улсын морьт харвааны наадам

Үндэсний ёс зан заншил, өв уламжлалаар дамжуулан Монгол Улсыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын жуулчдыг татах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Хийморь” олон улсын морьт харвааны наадмыг 3 дахь жилдээ нийслэлийн Засаг даргын 2021 оны А/691 дүгээр захирамжийн хүрээнд “Монголын морьт харваачдын холбоо”-той хамтран 09 дүгээр сарын 04,05-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулж, тэмцээнд Монгол Улсаас Хан Монгол морьтны холбоо, Дэлт сум клуб, Хаадын хаан клуб, Эвт сум клуб зэрэг 6 клубийн шилдэг 24 харваач, Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Швед, Франц, Унгар улсаас 20 гадаадын харваач, нийт 44 харваачид оролцож, цахим наадмыг олон нийтийн сүлжээгээр 32.659 хүнд хүргэсэн.



“Playtime” наадам

-Орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг дэлхийд сурталчлах зорилгоор зохион байгуулагддаг “Playtime” наадмыг Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 176, 259 дүгээр тогтоолын хүрээнд арга хэмжээ цуцлагдсан. Наадмын зурагт танилцуулга, мэдээллийг газрын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд сурталчлан 5267 хүн үзэж сонирхсон.



“Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг”

Монгол үндэсний хоолны соёлыг гадаад, дотоодын жуулчдад таниулах, жуулчдад зориулсан арга хэмжээний тоог нэмэгдүүлэх, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор нийслэлийн Засаг даргын 2021 оны А/691 дүгээр захирамжийн хүрээнд “Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг”-ийг “Монголын Зочид буудлуудын холбоо” ТББ, “Монголын Гастроном аялал жуулчлалын холбоо” ТББ-тай хамтран М.Ханддоржийн өргөө цогцолборт 09 дүгээр сарын 20-ны өдөр цахимаар зохион байгуулж, өдөрлөг оролцсон шилдэг 10 рестораны Монгол үндэсний нэрийн хоол болон Монголын Гастроном аялал жуулчлалын холбооны урласан 5 төрлийн тансаг идээ ундааны дисплей танилцуулгыг гадаад дотоодын жуулчдад зориулсан видео нэвтрүүлэг, контентийг 8 телевиз, “Артгэр”, “Юм олж идий”, “Аяллын тойрог”, “Монголын гастроном аялал жуулчлалын холбоо”, газрын цахим хаягуудаар сурталчлан арга хэмжээний контентийг нийт 169,375 хүн үзэж сонирхсон.




- <https://www.youtube.com/watch?v=p3reAyyq0j4&t=762s>
- <https://www.youtube.com/watch?v=WHnmHCBY6nE&t=870s>
- <https://www.youtube.com/watch?v=IOFfAEvOOg&t=148s>
- <https://www.youtube.com/watch?v=i8-V1ahti08&t=9s>

“Уухай” шагайн харвааны наадам

Үндэсний ёс зан заншил, өв уламжлалаар дамжуулан тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор “Уухай” шагайн харвааны наадмыг Монголын Шагайн харвааны холбоотой хамтран 10 дугаар сарын 17-ны өдөр Монгол бөхийн өргөөнд цахимаар зохион байгуулж, наадамд нийт 63 баг 504 тамирчид оролцон цэц мэргэнээ сорьж тэргүүн, дэд, гутгаар байр, шилдэг 4 багийг шалгаруулж цом, медаль, өргөмжлөл гардуулсан.

“Уухай” шагайн харвааны наадам удирдамж, зурагт хуудас, сурталчилгааны танилцуулга, контент нэвтрүүлэг бэлтгэн нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Шагайн холбооны цахим хуудсанд байршуулж 34,700 хүн, шигшээ багуудын тоглолтын шууд дамжуулалтыг 76,600, нийт 111,300 хүн үзэж сонирхсон.



“Улаанбаатар явган аяллын фестиваль”

Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 382 жилийн ойг тохиолдуулан “Монголын явган алхалтын холбоо”, “Монгол Оллэ нийгэмлэг”-тэй хамтран “Улаанбаатар явган аяллын фестиваль”-ийг 10 дугаар сарын 23-ны өдөр Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт байрлах Монгол Оллэ шинэ маршрутаар 3 дахь жилдээ зохион байгуулав. -Налайх дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр Өгөөмрийн аманд байрлах “Монгол Оллэ” явган аяллын 3 дугаар зам /17км/-ын нээлтийн арга хэмжээнд газрын дарга А.Ариунгэрэл, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын дарга н.Дуламсүрэн, БНСУ-ын Элчин сайдын зөвлөх Ким Чоль Сан болон бусад албаны хүмүүс оролцлоо. -“Монгол Оллэ” явган аяллын тусгайлан тохижуулсан, тэмдэгжүүлсэн уг замаар нийт 150 гаруй явган алхагчид хамрагдсан бөгөөд “Улаанбаатар явган аяллын фестиваль”-ийн арга хэмжээний 2 контентийг цахимаар нийт 59,342 хүн хүргэсэн.

<https://www.facebook.com/103375625081756/videos/1089003631637262>
<https://www.youtube.com/watch?v=1qgpFtyWwa4>





3. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийгэм, соёлын нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд:


Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр:

“Улаанбаатар Травэл Экспо-2021” үзэсгэлэн


Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын мэдээллийг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоо хамтран 7 дахь жилдээ “Улаанбаатар Травэл Экспо-2021” үзэсгэлэнг 2021 оны 05 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулав. Цахим үзэсгэлэнгээр аялал жуулчлалын салбарын 107 байгууллага оролцон бүтээгдэхүүн үйлчилгээ, аяллын багц, хөнгөлөлт урамшууллаа танилцуулан, 10-50% хөнгөлөлтийг иргэдэд үзүүлсэн. Мөн Монголд үйл ажиллагаа эрхлэгч компаниудын санал болгох шинэ аяллын маршрут, үнэ болон бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга, гадаадад аялуулагч тур оператор компаниудын бүтээгдэхүүн, клубуудын танилцуулга зэргийг сонирхох боломжийг www.ubtourism.org цахим хаягаар авах боломжийг бүрдүүлсэн. Цахим үзэсгэлэнгийн үеэр 21 аймгийн танилцуулга, инфографик, “Мэргэжилтнүүдтэй хамт 3 минут” цуврал 9 төрлийн видео контент, цар тахлын үеийн аялал жуулчлалын тухай видео зэргийг иргэдэд танилцуулан цахимаар зохион байгуулав.



Улаанбаатар трافل экспо үзэсгэлэнгийн үеэр Улаанбаатар аялал жуулчлалын холбооны www.ubtourism1.org цахим хаягт нийт 107 аж ахуйн нэгж тур оператор, гэр бааз, ТББ, аяллын дэлгүүр, аяллын клуб, даатгал болон бусад байгууллагууд талаар мэдээ мэдээлэл, 10-50%-ийн хямдрал урамшууллыг байршуулав.



Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Сонгинохайрхан уулын явган аяллын чиглэлийг тохижуулах тухай” А/397 дугаар захирамжийн дагуу ажлын зураг, төсөв, архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулсан. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын НХААГ-21/074 дугаартай Сонгинохайрхан уулын явган аяллын чиглэлийг тэмдэгжүүлэх, амрах цэгүүдийн тохижуулах ажлыг гүйцэтгэхээр “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн “Люксландшафт” гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлэн тохижилтын ажлыг 12 дүгээр сарын 10-ны өдөр хүлээж авсан.



Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран Чингэлтэй хайрханы явган аяллын замын тохижилтын ажлыг сэргээн засварлах ажлын хүрээнд мэдээллийн самбаруудад байршуулах мэдээллийг шинэчилсэн.



Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/370 дугаар захирамжаар Богдхан уулын Зайсан-Дугуй цагаан чиглэлийн явган аяллын замыг тохижуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан, тус газраас Богдхан уулын “Авто зогсоол - Дугуй цагаан” чиглэлийн явган аяллын замын тохижилтын ажлын саналыг танилцуулж, Ажлын хэсгийн хурлын шийдвэрээр архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг төсөл нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газарт хийгдэж байна.



4. Аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах чиглэлээр:

“Бодлогын баримт бичиг, төлөвлөгөө боловсруулах” зорилтын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 216 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалын хүрээнд газрын даргын 2021 оны А/57 дугаар тушаалаар нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, Ажлын хэсгээс “Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-тэй уялдуулан 5 зорилт, 10 стратеги арга хэмжээ, 32 ажил үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулсан.

“Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулах ажлын хүрээнд суурь судалгааны маягтыг боловсруулж, судалгааг Монголын Аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллагууд болон байгууллагын цахим хуудаст байршуулан цахимаар авсан. Арга хэмжээний төслийг боловсруулах Ажлын хэсгийг Үндэсний хөгжлийн газар, салбарын төлөөллүүдээс оролцуулан 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 2021 оны 07 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд арга хэмжээний төслийн загварыг боловсруулан, төслийг 7 зорилтын хүрээнд боловсруулж, төсөлд газрын албан хаагчид, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, харьяа агентлагууд, иргэд, олон нийт болон салбарын мэргэжлийн холбоодоос саналыг авч, нэгтгэж, нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогчид төслийг танилцуулан

нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчид, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдээс санал авч ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/679 дүгээр тушаалаар байгуулагдсан “Ковидын дараах аялал жуулчлалын салбарыг сэргээх санал боловсруулах Ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаатай уялдуулан “Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, холбогдох албан тушаалтан болон байгууллагуудаас санал авч нэгтгэн, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Аялал жуулчлалын Зөвлөлийн даргад танилцуулж, зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор боловсруулсан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөлд тусгах санал, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийг тэлэх, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах Эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төсөлд тусгах санал, Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд тусгах саналыг тус тус Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Улсын онцгой комисс, Гадаад харилцааны яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас боловсруулж буй “Аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, түр журмын төслийн төсөлд коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг цар тахлын нөхцөлд зохицуулах, гадаадын иргэд, жуулчдыг хүлээн авах тухай нөхцөл шаардлагыг тусган саналаа Ажлын хэсэгт хүргүүлэн ажилласан.

Нийслэлийн Засаг Даргын 2021 оны А/715 дугаар захирамжаар Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөний төслийг нэгтгэн боловсруулах ажлын хэсэгт 09 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд ажиллаж, 09 дүгээр сарын 30-ны өдөр Монголын Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо, Улаанбаатар аялал жуулчлалын холбоо, Монголын Зочид буудлуудын холбоо, Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв, Миний Тэрэлж жуулчны баазуудын холбоо, Монголиан гайд тур ХХК, Нью-Жуулчин ХХК зэрэг салбарын төрийн бус байгууллагуудыг хамруулан хэлэлцүүлэг хийж, Улаанбаатар-2040 он хүртэл хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институтэд хүргүүлсэн.

5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, УБ хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах, үйл ажиллагаанд мэргэжлийн холбоодын зөвлөмж, санал, дүгнэлтийг тусгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

Статистик, судалгааны чиглэлээр:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ, “Монгол банк”, “Үндэсний статистикийн хороо”, “Потеншил Рисерч” компанийн төлөөллүүдтэй уулзаж, салбарын судалгааны аргачлал, маягтад Улаанбаатар хот болон дотоодын аялагчдын судалгааны загварыг оруулах, судалгаа авах аргачлал, маягыг шинэчлэх, мэдээллийн нэг урсгалыг бий болгох нэгдсэн маягт, аргачлалыг шинэчлэн гаргахад хамтран ажилласан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газраас 2021 оны 06-аас 10 дугаар сар хүртэлх жуулчны статистик мэдээг, Хил хамгаалах ерөнхий газраас 01-10 дугаар сарын Монгол Улсын хилээр нэвтэрсэн иргэдийн судалгааг авч, нэгтгэн байгууллагын вэб сайтад байршуулав.

Аялал жуулчлалын салбарын Улаанбаатар хот, Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёлын салбарт үзүүлж буй нөлөөлөл, аялал жуулчлалын голлох зах зээлийн орнуудын судалгаа, Монгол улсад аялж буй жуулчдын зардал, сэтгэл ханамж, аюулгүй байдал, жуулчин хүлээн авах үйлчилгээний байгууллагууд болон аялал жуулчлалын голлох маршрутын хүчин чадал, нөөц даац, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон судалгааг хамтран зохион байгуулах саналыг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.

6. Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах ажлыг хариуцан зохион байгуулах, энэ чиглэлээр маркетингийн стратеги, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

“KOTFA”-Солонгосын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага “Korea World Travel Fair”-аас UNWTO-НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (United Nations World Tourism Organization), PATA-Ази, Номхон далайн бүсийн аялал жуулчлалын холбоо (Pacific Asia Travel Association), БНСУ-ын Соёл, спорт, аялал жуулчлалын яамтай хамтран Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо 6 дугаар сард зохион байгуулагдсан 36 дахь удаагийн “КОТФА” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Элчин Сайдын яам, МИАТ ХХК, “Mongolia 7 Days” зэрэг аялал жуулчлалын байгууллагууд оролцсон. Тус газраас Сөүл дэх Улаанбаатар хотын төлөөлөгчтэй хамтран Улаанбаатар хотын тухай видео танилцуулга, сурталчилгааны материалыг 1000 гаруй жуулчдад өгсөн. Улаанбаатар хотын видео танилцуулга, Монголын үндэсний хувцасны үзүүлбэр, урлагийн тоглолт, уран зураг, бэлэг дурсгалын худалдаа зэргийг зохион байгуулж үзэсгэлэнд дэлхийн 70 улсын ЭСЯ, иргэний нисэхийн компаниуд болон дотоод, гадаадын аялал жуулчлалын 200 гаруй байгууллага үйл ажиллагаагаа танилцуулж, 13,000 гаруй хүн үзэж сонирхсон.



Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Монголын Аялал жуулчлалын холбоо хамтран "ITM 2021" аялал жуулчлалын үзэсгэлэн "Хүртээмжтэй аялал жуулчлал" уриан дор 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 3 хоног Мишээл экспо төвд зохион байгуулагдлаа. Энэ удаагийн үзэсгэлэнд Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь нийслэл хотод аялал жуулчлалын чиглэлээр баримталж байгаа бодлого, шийдвэрийг сурталчлах, эвент арга хэмжээнүүдийг сурталчлах, гадаад, дотоодын иргэд жуулчдад үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэй чанартай болгохын тулд аялал жуулчлалын байгууллагууд, иргэдийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, түншлэл тогтоох, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, хотын аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, нийслэлийн иргэд, хүүхэд залууст хотын түүх, соёл, дурсгалт газар, дурсгалт барилга, үзмэрүүд, хотын өнөөгийн хөгжлийг танилцуулж, улмаар бахархах, хайрлах, хамгаалах сэтгэгдлийг төрүүлэх, иргэдийн аяллын боловсролыг дээшлүүлэх, хотын соёлд суралцуулах зорилготойгоор "Сити тур" төслийг танилцуулж нийт 800 гаруй иргэдэд мэдээлэл өгч ажиллав.



7. Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон ТББ-тай хамтран ажиллах ажлын хүрээнд:

Цагдаагийн Ерөнхий газраас ирүүлсэн гадаадын иргэд, жуулчид гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, өртөж хохирсон иргэдийн бүртгэл судалгаанд дүн шинжилгээ хийж, 2016 онд 148, 2017 онд 143, 2018 онд 161, 2019 онд 166 буюу 618 гадаадын иргэн хохирсноос 478 буюу 77.3 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, захиргааны зөрчилд холбогдон шалгагдаж байгаа болон өртсөн гадаадын иргэдийн 82.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

№	Бүртгэл	2016 он		2017 он		2018 он		2019 он		2020 он		
		Улсын хэмжээнд	Үүнээс: Нийслэлд	Улсын хэмжээнд	Үүнээс: Нийслэлд	Улсын хэмжээнд	Үүнээс: Нийслэлд	Улсын хэмжээнд	Үүнээс: Нийслэлд	Улсын хэмжээнд	Үүнээс: Нийслэлд	Үүнээс: Жуулчин
1	Монгол улсад амьдарч байгаа гадаадын иргэд, жуулчид гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэрэг үйлдсэн	63	47	53	37	61	21	54	42	21	15	1
2	Монгол улсад амьдарч байгаа гадаадын иргэд, жуулчид гэмт хэрэгт өртөж хохирсон	148	126	143	109	161	122	166	121	53	51	2
3	Захиргааны зөрчилд холбогдон шалгагдсан болон өртсөн гадаадын иргэд	96	75.40%	98	56.20%	105	74.70%	85	76.90%	36	82.50%	
Нийт дүн		307		294		327		305		110		

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” А/752 дугаар захирамжийн хүрээнд

Газрын даргын 2021 оны А/60 дугаар тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, батлагдсан төсвийн хүрээнд гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй аялах видео контент, аяллын үед коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 2 төрлийн контент хийх ажлыг гүйцэтгүүлж, урьдчилан сэргийлэх аюулгүйн видео зөвлөмжийг олон нийтийн сүлжээгээр 21,787 хүнд хүргэсэн.



Монгол Улсад гадаадын иргэд, жуулчид гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, өртөж хохирсон 2016-2019 оны судалгаагаар 77.3 хувь ... See more



Монгол Улсад гадаадын иргэд, жуулчид гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, өртөж хохирсон 2016-2019 оны судалгаагаар 77.3 хувь ... See more



Vanchindorj Batchimeg and 35 others 173 shares • 12K Views



Vanchindorj Batchimeg and 35 others 173 shares • 12K Views

Монгол улсад аялах хугацаандаа коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэм, зөвлөмжийг дагаж мөрдөх санамж, жуулчны мэдээллийн төвийн мэдээлэл, шаардлагатай утасны жагсаалт болон урьдчилан сэргийлэх санамж бүхий 2 төрлийн 10.000 ширхэг санамж хийж, мэдээллийн төвд байршуулсан.

Visit Ulaanbaatar
COVID-19 REMINDER
 Follow the infection control regimens, suggestions, and procedures below to avoid contracting the coronavirus during your trip to Mongolia.


- Keep a vaccination certificate with you at all times.
- Maintain a safe gap between people and greet them from distance.
- When visiting entertainment and service organizations, as well as public areas, use a normal mask and change it every two hours.
- Hand sanitizers containing alcohol should be used on a regular basis.
- As far as possible, avoid using cash and instead rely on credit and debit cards.
- If available, rinse your mouth and throat for 1 minute with a 2 percent soda solution or a 0.7 percent povidone iodine solution.

CORONAVIRUS


TRANSMISSION
 Contaminated air, Contaminated objects, Incubation (5-14 DAYS), Stay At Home.

SYMPTOMS
 Fever, Cough, Muscle ache, Headache, Shortness of breath. Wear Mask If You Caring For Someone With Symptoms.


PREVENTION
 Wash your hands, Use an alcohol-based hand sanitizer, Cover your cough or sneeze with a tissue, Avoid touching your eyes, nose and mouth, Disinfect frequently touched objects, Avoid contact with sick people.




ULAANBAATAR CITY TOURISM DEPARTMENT
IMPLEMENTING AGENCY OF THE MAYOR




Visit Ulaanbaatar
Tourist information center




CITY GOVERNOR'S OFFICE



ULAANBAATAR CITY TOURISM DEPARTMENT



NATIONAL POLICE AGENCY OF MONGOLIA



Branch 1: Ulaanbaatar city Chingeltei District, 4khoroo, Administration house IV
// supreme translated aboard
Monday-Friday, 09.00am – 06.00pm
Telephone: + (976) 70108687

Branch 2: Central Post Office Building, Sukhbaatar square 1, Chingeltei district 1st khoroo Ulaanbaatar 15160
// performed keen positive
Every day, 09.00am – 08.00pm
Telephone: + (976) 70108687 www.visitulaanbaatar.net

Sergelen sum, Tuv aimag, Mongolia Chinggis khaan international airport
Monday-Friday 09.00am – 06.00pm
Phone: +(976) 70108687


THE ULAANBAATAR CITY TOURISM DEPARTMENT WELCOMES YOU TO UB

Ulaanbaatar is relatively safe place. Nevertheless, there are some common sense precautions to keep in mind.

- > Please be alert by protecting your documents and valuable items while traveling via public transportation or in public places.
- > It is recommended not to carry with you large amounts of cash and other items consider to be valuable.
- > Avoid traveling during the late night hours, especially if in unfamiliar locations.

USEFUL NUMBERS UB Tourist Information Hotline + (976)70108687, POLICE -102
Fire -101, Ambulance -103, Emergency -105, Railway inquire -1900-1949, Airport inquire -1900-1980 Call Center 1800-1950 / Paid /

“Ковид-19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аяллын үед коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий контент хийлгэж, салбарын үйлчилгээний байгууллага, байр сууцны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хүргэж олон нийтэд сурталчилсан.



8. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтийг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод сургалтад хамруулж, мэргэшлийг дээшлүүлэх ажлын хүрээнд:

Бүгд найрамдах Хятад Ард Улсын Хайнань хотын Худалдааны газар, бизнесийн сургалтын төвөөс “Хөгжиж буй орнуудын аялал жуулчлал ба зочид буудлын менежмент” сэдэвт 2021 оны 07 дугаар сарын 01-14-ний хооронд зохион байгуулагдсан цахим сургалтад зочлох үйлчилгээний салбарын 12 ажилтанг хамруулж, цахимаар гэрчилгээ олгосон.

Хүннүгийн эзэнт гүрний язгууртны булш, оршуулгын дурсгалт газруудыг ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвийн жагсаалтад бүртгүүлэх бэлтгэл ажлын хүрээнд “Хүннүгийн эзэнт гүрний язгууртны булш оршуулгын дурсгалууд: судалгаа, хадгалалт, хамгаалалт, сурталчилгаа” сэдэвт Үндэсний семинарыг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулж 30 хөтөч, тайлбарлагчдыг хамруулсан.

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран байгаль хамгаалагчид болон тус бүс нутагт аялал жуулчлалын дагалдах үйлчилгээ үзүүлдэг /морь, тэмээ унуулах, нохойтой чарга, дүүжин гүүр, гэх мэт/ иргэдийн дунд хууль эрх зүй, эрүүл ахуйн мэдлэг олгох сургалтыг 2021 оны 7 дугаар сард зохион байгуулж, 30 иргэнийг хамруулав.



Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран хөтөч, тайлбарлагч, дэн буудлын ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчдын харилцаа хандлага, жуулчин тээвэр, такси үйлчилгээний ажилчдад зориулсан хууль эрх зүй, аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр, төсвийн зардлын төслийг боловсруулж нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд хүргүүлж, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2021 оны “Эрх шилжүүлэх тухай” 135 дугаар дагуу газрын даргын тушаалаар сургалтын видео шторкийн ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг байгуулж, “Монголын Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо” ТББ, “Аялал жуулчлалын сургалт, зөвлөгөөний Нона фамили” ХХК, “Жуулчин тээврийн холбоо” ТББ, “Аялал жуулчлалын ур чадварын МСҮТ”, “Ай хотел” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан цахим сургалтын 4 видео контентийг гүйцэтгүүлж байна.



9. Улаанбаатар хоттой хамтын ажиллагаатай хотуудтай аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, нийслэл хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/345 дугаар захирамжаар Улаанбаатар хот орчмын түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалтын бүсийг тогтоолгох ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулан хурлаар хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын танилцуулга, мэдээллийг сонсож, газруудын хамгаалалтын бүсийн газрын хэмжээг тогтоолгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, хамгаалалтын бүс тогтоолгох 5 байршилд Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2 удаа очиж ажиллан хээрийн судалгааны ажил зохион байгуулж, хамгаалалтын бүс тогтоолгох цэг, газрын талбайн хэмжээг гаргасан.


Түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалтын бүс тогтоолгох талбайн хэмжээ:

- ✓ Их тэнгэрийн амны хадны зураг
- ✓ Гачууртын амны хадны зураг
- ✓ Туулын Хар түнийн ордны туурь
- ✓ Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолбор
- ✓ Ар гүнтийн дөрвөлжин булшнууд

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн ээлжит хуралдаанаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалтын бүс тогтоолгох асуудлыг хэлэлцүүлэн дэмжүүлж, хамгаалалтын бүс тогтоолгох саналыг Нийслэлийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 1/1067 дугаар албан бичгээр Соёлын яаманд хүргүүлсэн.




Улаанбаатар хотод ирж буй гадаад, дотоодын жуулчдыг татах, хотын аяллын шинэ бүтээгдэхүүн бий болгож зорин очих газрыг нэмэгдүүлэх, түүх, соёлын дурсгалыг олон нийтэд сурталчлан таниулах, аялал жуулчлалын эргэлтэд оруулах зорилгоор Баянзүрх дүүргийн 11-р хороо, Их тэнгэрийн амны хадны зураг орчны тохижилтын ажлын хүрээнд МЗХ2021/13-022 архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулж, тохижилтын ажлын зураг төсөл, төсвийг “Хязгааргүй шулуун” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэн ажлын зургийг нийслэлийн Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын даргаар батлуулсан. Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Их тэнгэрийн амны хадны зургийн орчныг тохижуулах тухай” А/676 дугаар захирамжийн хүрээнд “Их тэнгэрийн амны хадны зураг”-ийн батлагдсан тохижилтын ажлын зураг, төсөв, архитектур төлөвлөлтийн даалгаврын материал холбогдох материалыг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн тендерийн ажлыг зохион байгуулж байна.



“Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” орчмын тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр хийхээр төлөвлөсөн. Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Ажлын зураг төсөл гүйцэтгүүлэх тухай” А/631 дүгээр захирамжийн дагуу кадастрын зураг, тохижилтын дэвсгэр зургийг “Шинэ кадастр” ХХК-ээр гүйцэтгүүлж, “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” орчмын тохижилт, бүтээн байгуулалтын ажлын МЗХ2021/13-021 дугаар архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулж, “Батдах” ХХК-тай гэрээ байгуулан тохижилтын ажлын зураг төсөл, төсвийн ажлыг гүйцэтгүүлж, тохижилтын ажлын хүрээнд Монгол, Унгар улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой, Монгол-Унгарын археологийн экспедицийн 60 жилийн ойд зориулан түүхэн дурсгалын багана /2x0.5/ босгохоор ажиллаж байна.

10. Аялал жуулчлалын байгууллагуудын дунд аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:

Байр сууцны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын удирдах болон үйлчилгээний ажилтнуудад зориулсан “Хууль эрх зүй, аюулгүй байдал, эрүүл ахуй, стандартын мэдлэг олгох” сургалтыг 2021 оны 07 дугаар сарын 21, 22-ны өдөр цахимаар зохион байгуулж нийт 160 ажилтан, албан хаагчийг хамруулсан.




Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй дэн буудлын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн үйлчилгээний чанар хүртээмж, стандартыг хангаж ажиллах, үйлчилгээний стандартыг сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах, хэвшүүлэх хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих зорилготой “Үйлчилгээний чанар-стандарт” сургалтыг Чингэлтэй, Сүхбаатар Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх дүүргийн жишиг дэн буудлуудын байранд Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Дүүргийн Засаг даргын Тамгын газар, “Өргөө” дэн буудлуудын холбоо ТББ, Айхотел ХХК, Хорека Софт ХХК нартай хамтран зохион байгуулж нийт 35 дэн буудлын удирдах албан тушаалтнууд хамрууллаа.




11. Гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр шуурхай хангаж, УБ хотын талаарх сурталчилгааны материалуудыг тогтмол шинэчлэх арга хэмжээ авч ажиллах талаар:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны танилцуулга, цахим аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай” А/624 дүгээр захирамжийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны танилцуулга видео хийх ажлыг “Херо интертаймент групп” ХХК, www.visitulaanbaatar.mn цахим хуудсыг гадаадын жуулчдад зориулсан Улаанбаатар хотын түүх, соёл, нүүдэлчин ахуйгаа авч үлдсэн орчин үеийн хот дүр төрхийг харуулсан дизайнтай, нүүр, хотын түүх, мэдээ, үйлчилгээний байгууллага, эвент арга хэмжээ, вертаул гэсэн 6 үндсэн цэстэй www.visitulaanbaatar.net /англи хэл/ дээрх цахим хуудас шинэчлэх ажлыг “Art agency” ХХК, Улаанбаатар хотын өнгө төрхийг харуулсан 360 градус эргэдэг 4 багц бүхий 25 зурагтай вертаул сан үүсгэх ажлыг “Эй Эл Жи Эс” ХХК-аар тус тус гүйцэтгүүлэн, хүлээн авч хөгжүүлэлтийг хийж ажиллаж байна.




Хотын талаарх сурталчилгааны материалуудыг тогтмол шинэчлэх ажлын хүрээнд “Ulaanbaatar your gateway to Mongolia” буюу Улаанбаатар сэтгүүл 2000 ширхэг, “Ulaanbaatar Official Visitor’s Guidebook” буюу Хөтөч ном 2000 ширхэг, “Ulaanbaatar official tourist map” буюу Хотын газрын зураг /эвхмэл/ 2000 ширхэг нийт 6000 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлсэн.



12. Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн үзэсгэлэн, арга хэмжээнд оролцох, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ-уудыг хамруулах талаар:

Дэлхийн өвлийн хотуудын дарга нарын 19 дэх удаагийн хурал 2021 оны 11 дүгээр сарын 05-16-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулагдлаа. Хуралд Rovaniemi, Norilsk, Novosibirsk, Ulaanbaatar, Changchun, Daqing, Harbin, Jilin, Qiqihar, Shenyang, Sapporo зэрэг нийт 9 улсын 22 хотын дарга, захирагч нар оролцсон бөгөөд нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга А.Ариунгэрэл, мэдээлэл сурталчилгааны төвийн менежер Д.Жавхлан нар оролцож, “Улаанбаатар хотын өвлийн аялал жуулчлал” сэдвээр илтгэл тавьж оролцлоо.



Унгар улсын нийслэл Будапешт хотноо 2021 оны 10 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан түүхийн ач холбогдолтой үнэт дурсгалын хадгалалт, хамгаалалт сэдэвт "HUN 2021" олон улсын хуралд тус газрын дарга А.Ариунгэрэл оролцлоо.

Будапешт хотын Обашар тосгонд байрлах 4-р Белла хааны удмын язгууртнуудын тахилын сүм, оршуулгын зан үйлийг сэргээн засварлаж буй малтлага судалгааны ажилтай танилцаж туршлага судалж, Монгол, Унгар улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой, Монгол-Унгарын археологийн экспедицийн 60 жилийн ойг хүрээнд Улаанбаатар хотын "Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш" түүх соёлын дурсгалыг тохижуулж, шинэ бүтээгдэхүүн бий болгон аялал жуулчлалын эргэлтэд оруулах зорин ажиллаж байна.



13. Жуулчдад зориулсан мэдээлэл сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар:

Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх жуулчны мэдээллийн төвүүдийг ажиллуулж байна. Үүнд:

- ✓ Нийслэлийн Засаг даргын 2021 оны "Жуулчны мэдээллийн төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай" А/31 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн Засаг захиргааны IV-р байранд Жуулчны мэдээлэл сурталчилгааны төв,
- ✓ Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аяллын компаниудтай хамтран мэдээлэл өгөх, тэдний бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, иргэдийн аяллын боловсролыг дээшлүүлэх зорилгоор Монголын бурхан шашны төв Гандантэгчэнлин хийдийн талбайд 07 дугаар сарын 01-нээс 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд Гэр мэдээллийн төв,
- ✓ Нийслэлийн Засаг даргын 2021 оны "Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төв ажиллуулах тухай" А/543 дугаар захирамжийн хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийн "Чингис хаан" Олон улсын нисэх онгоцны буудалд олон

улсын стандарт (ISO 14785)-д нийцсэн “Жуулчны мэдээллийн төв”-ийг Аялал жуулчлалын хөгжлийн төв (ТӨҮГ)-тэй хамтран шинээр ажиллуулсан.



14. Жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, тэдгээрийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах талаар:

Гадаадын иргэдийн санал гомдлыг хүлээн авах, мэдээлэл, зөвлөгөөг түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх зорилгоор Жуулчны лавлах утас 70108687 дугаарын утсаар дотоод, гадаадын иргэд, жуулчдаас жилд дунджаар 2000-5000 дуудлага ирж, мэдээлэл өгч ажилладаг. 2021 онд 3 жуулчны мэдээллийн төв, 2 үзэсгэлэн, арга хэмжээний үеэр 2970 гадаад, дотоодын иргэдэд мэдээлэл өгч ажиллалаа.

Байгууллагын www.ub.gov.tourism.mn цахим сайтад 68 удаагийн мэдээ, нийслэлийн Аялал жуулчлалын газрын пэйж хуудсанд байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулсан эвент арга хэмжээ, цаг үеийн нийт 411 удаагийн мэдээ мэдээлэл, 28 удаагийн видео шторк байршуулж, 653.234 хандалттайгаар цахимаар сурталчлан ажилласан.

15. Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх талаар:

“Цахим шилжилт” төслийн хүрээнд “Цахим Улаанбаатар” аяныг 06 дугаар сарын 15-ны өдрөөс 08 дугаар сарын 30-ний өдрүүдийн хооронд зохион байгуулж, зочлох үйлчилгээний байгууллагуудыг цахимжуулах, зочин бүртгэлийн цахим системд холбох ажлыг “Horeca soft”, “I-Note” зэрэг програм хангамжийн байгууллагуудтай хамтран 75 аж ахуйн нэгжийг зочин бүртгэлийн цахим системд холбосон.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байр сууцны үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бүртгэж, мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх ажлын хүрээнд 254 зочид буудал, 133 дэн буудал, 87 амралтын газар, жуулчны баазын мэдээ, мэдээллийг шинэчлэн бүртгэн сан үүсгэсэн.

Мэдээлэл, сурталчилгааны төвүүдийн мэдээллийн нэгдсэн санд нийслэл, орон нутгийн аялал жуулчлал, соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд /тур оператор компаниуд, байршуулах хэрэгслүүд, музей галерей, урлагийн байгууллага, үзвэр үйлчилгээний газар, номын дэлгүүр/-ын болон түүх соёлын дурсгалт газрууд гэх мэт 2000 гаруй байгууллагын мэдээллээр мэдээллийн сан үүсгэж, үзвэр, худалдаа, үйлчилгээний хуваарь, аялал жуулчлалын чиглэлээр болон бусад эвент арга хэмжээний мэдээ, мэдээлэл зэрэг 10.000 гаруй мэдээллийг бэлтгэж, шинэчлэн ажиллаж байна.

16. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх талаар:

Эрхэлсэн асуудлын хүрээнд Улсын Онцгой комисс, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гадаад харилцааны яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын

холбогдох хэлтсүүд, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, нийслэлийн 9 дүүрэг, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагууд, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа их дээд сургуулиуд, төрийн бус байгууллагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээ мэдээллийг цаг тухайд түргэн шуурхай өгч ажиллаж байна.

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн 40 үүрэг даалгавраас чиг үүргийн хүрээнд заалт тус бүрээр биелэлтийг ханган, хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь www.ulaanbaatar.mn програмаар тайлагнан ажиллав.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хуулийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ, мэдээлэл, холбогдох судалгааг тухай бүр цаг хугацаанд нь хүргэж ажилласан.


17. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах талаар:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга А.Ариунгэрэл Унгар улсын Элчин сайд Обрушански Борбалатай уулзаж, Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш цогцолборыг тухайн үеийн хэв шинжийг хадгалсан байдлаар тохижуулах, жуулчдын хувьд он цагийн аялал хийх боломжит нөхцөлийг бүрдүүлсэн байхаар төлөвлөн хамтран ажиллаж байна.




Улаанбаатар, Бангкок хотууд нь хот хоорондын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд Бангкок хотын хөгжил, залуусын үйл ажиллагааг сурталчилсан, иргэд болон хот хоорондын солилцоог дэмжих, соёл, аялал жуулчлал, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой видео контентыг газрын www.tourism.ub.gov.mn цахим хуудсаар сурталчилсан.

Бүгд Найрамдах Солонгос Улсын “Жэжү Оллэ” нийгэмлэгтэй хамтран “Монгол оллэ” төслийг Налайх дүүрэгт үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр Налайх дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазар, БНСУ-ын Жэжү Оллэ нийгэмлэгийн Монгол дахь төслийн удирдагч Kim Dong Wook нар хамтран ажиллах гурван талт төлөвлөгөөг баталлаа. Уг төлөвлөгөөнд аялал жуулчлалаар дамжуулан нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ажлын байртай болгох, сургалт зохион байгуулах, иргэдийг байгальд ээлтэй аялах дадлыг бий болгох, явган аяллын зам жим тохижуулах, жуулчны мэдээллийн төв байгуулах зэрэг ажлуудыг тусгасан.



Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн Улаанбаатар хотод тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор нийслэлийн мотоцикл, мото спорт сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, түүгээр дамжуулан түүх соёл, ёс заншил, өв уламжлалаа олон нийтэд сурталчлах, залуусын эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, хөрш зэргэлдээ болон гуравдагч орнуудад эх орноо сурталчлах, “Талын салхи” мото наадмыг Ази тив, олон улсын чанартай томоохон мото фестивалийн хэмжээнд өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг чиглэл болгон хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор гурван улсын “Цайны зам” олон улсын аялал жуулчлалын холбооны хүрээнд “Монголын Чопперчин ахан дүүс” НҮТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.




Дөрвөн хайрханы явган аяллын маршрутыг засварлан, тохижуулах, хот орчмын явган аяллын үйл ажиллагааг дэмжих, явган аяллын алхагч нарт зориулсан зөвлөмж, гарын авлагыг боловсруулан иргэдийн аялал жуулчлалын боловсролыг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийг “Монголын явган алхалтын холбоо” ТББ-тай байгуулсан.



Улаанбаатар хот орчмын түүх, соёлын үл хөдлөх дурсгал, биет өвийг хамгаалан хадгалах, судлах, олон нийтэд сурталчлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгож эргэлтэд оруулах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.



Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг чадваржуулах сургалт, эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар стандартыг сайжруулах чиглэлээр Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.



Монгол Улсын Соёлын яам, нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-аас хамтран 2021 оны 11 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулсан “Соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөн 2021” хэлэлцүүлэгт “ЖДҮҮ эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг аялал жуулчлалаар дамжуулан эргэлтэд оруулах” сэдвээр илтгэл тавьж, соёлын бүтээлч үйлдвэрлэл ба эдийн засгийн үр өгөөж, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөгжүүлэх шийдэл, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарыг соёлын аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх боломжийн талаар хэлэлцүүлэгт оролцлоо.



Монгол Улсын Соёлын яамнаас зохион байгуулж буй “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд Монголын арьсан урлагийн “Хүрэл буга” нийгэмлэг, Монголын “Шувуулахуй” холбооны хамтран 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан “Шувуучлахуй” үзэсгэлэн, бага хуралд оролцож соёлын биет бус өвийг аялал жуулчлалын эргэлтэд оруулж сурталчлан таниулах талаар хэлэлцэв.



Нийслэлийн 382 жилийн ой, Дэлхийн Аялал жуулчлалын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд нийслэлийн Боловсролын газар, “Соёлын солилцоо хөгжлийн төв” ТББ-тай хамтран E-bus city tour хотын аяллыг 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын 09, 10 дугаар ангийн сурагчдын дунд “Агаарын бохирдол ба Миний хот” сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд шалгарсан сурагчдыг хотын бүтэн өдрийн автобустай аялалд хамруулсан.



18. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийн хүрээнд:

А. Зохион байгуулалтын чиглэлээр:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан 2021 оны “Хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилтийг хангах 11 заалт бүхий төлөвлөгөөг баталж, хэрэгжилт 94.45 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улаанбаатар хотод аялал жуулчлал хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төсвийг хэлэлцэх, салбар хоорондын уялдааг хангах, чиг үүрэг бүхий “Улаанбаатар хотын аялал жуулчлалын дэмжих зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/79 дүгээр захирамжаар батлуулсан.

Зочид буудлын ерөнхий шаардлага стандарт MNS4588:2008, аялал жуулчлал дэн буудлын ерөнхий шаардлага стандарт MNS5738:2007-г шинэчлэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2021 оны А/23 тушаалаар, дэд ажлын хэсгийг газрын даргын тушаалаар байгуулж, зочид буудал, дэн буудлын стандартын төсөлд 11 төрийн байгууллага болон 7 төрийн бус байгууллагаас санал авч төслийг боловсруулан Стандарт, хэмжил зүйн газрын Техникийн хороогоор хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны А/313 дугаар тушаалаар “Дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох журам”-ийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, Ажлын хэсгээс журмын төслийг шинэчлэн боловсруулан гурван удаагийн хэлэлцүүлгийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

Б. Цаг үеийн ажлын шаардлагаар дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаар:

“Ковид-19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагуудын салбар хоорондын харилцан ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд.



“Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшин тогтоож, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн Засаг даргын 2021 оны А/25 захирамжаар зочид буудлын үйл ажиллагааг нээсэнтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэм, нийтлэг болон тусгай нөхцөл шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэхэд хэсэгчилсэн үзлэг, шалгалтыг зохион байгуулж, 13 аж ахуйн нэгжийг хамруулж, зөвлөмж өгч ажиллаа.



Нийслэл хотод тусгаарлан ажиглах байраар ханган байрны нөөц бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2021 оны А/32 дугаар тушаалаар баталсан хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, тусгаарлан ажиглах байрны нөөц бүрдүүлэх удирдамжийн дагуу холбогдох мэргэжлийн болон хяналтын байгууллагуудын төлөөлөл бүхий 7 дэд ажлын хэсэг 2021 оны 02 дугаар сарын 05-аас 08-ны өдрүүдэд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа тусгаарлан ажиглах байраар ажиллах боломжтой 25-аас дээш өрөөтэй 62 зочид буудалд үзлэг зохион байгуулж ажилласан.



Улаанбаатар хотод 3177 ор, 1844 өрөө бүхий 39 тусгаарлан ажиглах байр буюу 37 зочид буудал, 2 амралтын газрын бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, гадаад улс орноос тусгай үүргийн нислэгээр ирсэн, дотоодын халдвар авсан иргэдийг байрлуулан ашиглаж байна.



Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй амралтын газар, жуулчны бааз, дэн буудлын үйлчилгээг үе шаттайгаар нээх шийдвэр гарсантай холбогдуулан коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, үйл ажиллагааг нь хэвийн үргэлжлүүлэх зорилгоор нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын Алба, нийслэлийн Аялал жуулчлалын газраас 2021 оны 07-р сарын 04-ний өдөр аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагуудтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, “Хариуцлагын гэрээ” байгуулан ажиллахаар шийдвэрлэсэн.



Дээрх шийдвэрийн хүрээнд “Хариуцлагын гэрээ” байгуулах нэгдсэн уулзалтыг 2021 оны 07 дугаар сарын 05-ны Соёлын төв өргөөнд зохион байгуулагдаж, уулзалтад нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын Албаны дарга Т.Гантөмөр, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Б.Бямбадорж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга А.Ариунгэрэл, төвийн зургаан дүүргийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн дарга нар, Монголын Аялал жуулчлалын холбооны төлөөлөл оролцож, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 124 дэн буудал, 153 амралтын газар, жуулчны баазтай Хариуцлагын гэрээ” байгуулж, 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс шинэчилсэн гэрээг 108 аж ахуйн нэгжтэй байгуулсан.



“Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”, халдварын тархалтын “Улбар шар түвшин”-д шилжүүлсэн хугацаанд “Хариуцлагын гэрээ” байгуулан ажиллаж байгаа үйлчилгээний газрууд болон үйл ажиллагаа нь хязгаарлагдаагүй худалдаа, үйлчилгээний газруудад халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлэх зорилгоор Улсын Онцгой комиссын 2021 оны 21, 23 дугаар хуралдааны тэмдэглэл, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/477, А/643 дугаар захирамж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын алба, нийслэлийн Цагдаагийн удирдах газар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нарын хамтран баталсан “Амралтын газар, жуулчны баазуудад Коронавируст халдвар /ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах 41 дүгээр түр журам”, “Хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих ажлын удирдамж”-ийн дагуу аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.





Хяналт шалгалтын ажлыг дүүргүүдийн Онцгой комисс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Засаг даргын Тамгын газрын Худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран 2021 оны 06 дугаар сарын 18-аас 29, 07 дугаар сарын 08-аас 09 дүгээр сарын 30-ны өдрүүдэд 9 дэд ажлын хэсгийн 56 албан хаагч Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Налайх, Багануур, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа давхардсан тоогоор 481 амралтын газар, жуулчны бааз, 30 зочид буудал, 80 дэн буудлыг хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан бөгөөд 29 аж ахуйн нэгжид 3-7 хоногийн хугацаатай зөрчил арилгах тухай мэдэгдэх хуудас өгч, 7 аж ахуйн нэгжид Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулж, сануулах арга хэмжээ авч ажилласан.

Нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан “Хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагаанд мөрдөх халдвар хамгааллын нийтлэг түр заавар”-ын дагуу тус газрын 5 албан хаагч 2021 оны 01 дүгээр сарын 26-31-ний өдрүүдэд Чингэлтэй дүүргийн 2, 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Улсын Их дэлгүүр”, “Пийс молл”, “Компьютер ланд” зэрэг худалдааны төвүүдэд иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж, зураглалыг гаргах чиглэлээр үйлчлүүлж буй иргэдийг QR кодоор бүртгэлжүүлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, хэрэгжилтэд хяналт тавьж цар тахлын халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар зөвлөмж өгч ажилласан.



“Ковид-19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагуудын салбар хоорондын харилцан ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд тайланд хугацаанд Улсын Онцгой комиссын шуурхай штабт 2 албан хаагч, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабт 3 албан хаагч хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 58 дугаар тушаалаар “Нэгдсэн шуурхай штаб” байгуулагдсан бөгөөд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Нэгдсэн шуурхай штабын орлогч даргын баталсан

“Нийслэлийн онцгой комиссын шуурхай штабт амралтын өдрүүдэд ажиллах ажиллах хуваарь”-ийн дагуу тус газрын 2 албан хаагч ажиллагааны багт ажиллаж үүрэг гүйцэтгэсэн ажиллаж байна.

Нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас коронавирусын халдварын үеийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх ажиллах хуваарь”-ийн хүрээнд тус газраас Баянзүрх дүүргийн 2, 6, 25 дугаар хороодын Өрхийн эрүүл мэндийн төвд 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс 10 дугаар сарын 29-ний өдрүүдэд дуудлага мэдээлэл, бүртгэл, багц савлах, түгээх зэрэг ажлуудад 4 албан хаагч тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн ажилласан.



Сайжруулсан түлшний нөөцлөлт, борлуулалт, түгээлтэд хяналт тавьж ажиллах ажлын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/779 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах, сайжруулсан түлшний борлуулалтын цэгийн түлшний нөөцийг бүрдүүлэх, цэгийн тоог нэмэгдүүлж жигдрүүлэх, тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, түлшний хэрэглээг жигд хүртээмжээр хангах зорилгоор тус газраас батлагдсан хуваарийн дагуу Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны 8, 18 дугаар хорооны 6, нийт 14 сайжруулсан түлшний цэгүүдийн нөөцлөлт, борлуулалт, түгээлтийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавьж ажиллан, тайлан мэдээг 7 хоног бүр дүүргийн Шуурхай штабт хүргүүлж ажиллаж байна.



Б/. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

“Албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд.

Хүний нөөцийн талаар төрөөс баримтлах бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Газрын даргын 2018 оны “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр батлах тухай” А/34 дүгээр тушаал, 2018 оны “Албан хаагчдын сургалтын хөтөлбөр батлах тухай” А/50 дугаар тушаалын дагуу хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны 14 заалт бүхий төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Тухайлбал:

Монгол Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2021 оны 04 дүгээр сард зохион байгуулагдсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт сертификаттай сургалтад 18 албан хаагч, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Удирдлагын академиас зохион байгуулсан “Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт “Алсын хараа-2050” сэдэвт сургалтад 3 удирдах албан тушаалтан хамрагдсан.



Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх замаар иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг чанар хүртээмжтэй, хөнгөн шуурхай хүргэх зорилгоор “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд нийслэлийн Сургалт, судалгааны төвөөс зохион байгуулсан 5 удаагийн багц сургалтад 21 албан хаагчийг хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлсэн.

Байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу нийслэлийн Сургалт судалгааны төвтэй хамтран “Стресс менежмент”, “Баг хамт олны үр дүнтэй харилцаа”, “Харилцан суралцах арга зүй” сэдэвт сургалтыг танхимаар зохион байгуулж 19 албан хаагчдыг хамруулж чадавхжуулсан.



БНСУ-ын Сэжун Их Сургуулийн Аялал жуулчлалын салбарын Дата судалгааны лаборатори (TIDAL), БОАЖЯ-тай хамтран Монголын Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд 2021 оны 04 дүгээр сарын 26-аас 05 дугаар сарын 07-ны хооронд зохион байгуулагдсан ""Аяллын хөтөч"-ийн цахим сургалт 2 албан хаагч, Нэгдсэн Үндэстний институтын сургалт, судалгааны байгууллагаас зохион байгуулсан “Дижитал өөрчлөлтийг түргэтгэх, бодлогыг хэлбэржүүлэх, хамтын хөгжил цэцэглэлтийг нэмэгдүүлэх” сэдэвт сургалтад 2 албан хаагч, Швейцарын хөгжлийн агентлаг, Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт технологи нэвтрүүлэгч “Айхотел” ХХК хамтран зохион байгуулсан “Аялал жуулчлалын салбарын цахим шилжилт сэдэвт сургалтад 2 албан хаагч буюу давхардсан тоогоор 18 удаагийн сургалтад 112 албан хаагчийг хамруулж, мэдлэг чадварыг нь дээшлүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу албан хаагчдын хувийн хэрэгт тухай бүр баяжилт хийж, төрийн албаны www.hr.csc.gov.mn нэгдсэн системд байгууллагын хүний нөөцийн мэдээллийг тухай бүр бүртгэлжүүлсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалын хүрээнд 17 төрийн жинхэнэ албан хаагчийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг эхний хагас жилийн байдлаар дүгнэхэд 12 албан хаагч “Маш сайн”, 3 албан хаагч “Сайн”, 2 албан хаагч “Ажил сайжруулах шаардлагатай” гэж дүгнэгдсэн.

Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгуулах тухай санал, төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх албан хаагчдын бүртгэл, мэдээллийг хүргүүлж, 1 албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулж, 3 албан хаагчийг тангараг өргүүлсэн.



Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж идэвх зүтгэл гаргасан ажилласан 3 албан хаагчийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шагналаар, 3 албан хаагчийг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шагналаар, 5 албан хаагчийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн шагналаар, 3 албан хаагчийг Монголын аялал жуулчлалын холбооны шагналаар буюу нийт 14 албан хаагчийг шагналд тодорхойлж, шагнаж урамшуулсан.



В. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ /КРИ-ЭЭР ҮНЭЛСЭН МЭДЭЭЛЭЛ

1. Жуулчдад зориулан зохион байгуулж буй эвент арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулж дотоод гадаадын иргэд, жуулчдын тоог нэмэгдүүлсэн байдал:

Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, нийслэлийн Онцгой комиссоос гаргасан шийдвэрүүдийн хүрээнд 10 эвент арга хэмжээг цахимаар зохион байгуулж, телевиз, сайт, шууд дамжуулалт, олон нийтийн сүлжээгээр 2,511,383 хүнд хүргэсэн байна.

Д/д	Эвент, арга хэмжээний нэр	Оролцогчдын тоо	Үзсэн хүний тоо /цахимаар/
1.	"Талын салхи" олон улсын мото наадам	-	Мэдээллийг 18,490 хүн үзсэн сонирхсон.
2.	"Улаанбаатар Травэл Экспо-2021" цахим үзэсгэлэн	Аялал жуулчлалын салбарын 107 байгууллага	Контентийг цахимаар 37,512 хүн үзэж сонирхсон.
3.	"Дээлтэй Монгол" наадам	Улаанбаатар хот, 20 аймаг, 9 дүүрэг, ХБНГУ, БНСУ, Япон, АНУ, Швед зэрэг улсаас нийт 5000 гаруй	Контентийг цахимаар 1,853,575 хүн үзэж сонирхсон.
4.	"Playtime" олон улсын амьд хөгжмийн наадам	-	Мэдээллийг 5,267 хүн үзсэн сонирхсон.
5.	"Хийморь" морьт харвааны олон улсын тэмцээн	Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Швед, Франц, Унгар 6 улсын 44 тамирчид	Контентийг цахимаар 32,659 хүн үзэж сонирхсон.
6.	"Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг"	Үндэсний хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг шилдэг 10 ресторан	Контентийг цахимаар 59,342 хүн үзэж сонирхсон.
7.	"Улаанбаатар явган аяллын фестиваль"	Фестивальд 150 гаруй явган алхагчид	Контентийг цахимаар 169,375 хүн үзэж сонирхсон.
8.	"Уухай шагайн харвааны наадам"	63 багийн 504 харваач	Контентийг цахимаар 111,300 хүн үзэж сонирхсон.
9.	"Солонгосын долоо хоног" арга хэмжээ	3 удаагийн нэвтрүүлэгт 18 хүн	Нэвтрүүлэгийг телевиз болон олон нийтийн сүлжээгээр 221,000 хүн үзсэн.
10.	"Чингис хааны төрсөн өдөр" хаадын чуулбар, "Шувуулахуй наадам"	-	Мэдээллийг 2,863 хүн үзсэн сонирхсон.
Нийт 10 эвент арга хэмжээ		5833 оролцогч	2,511,383 хүн үзэж сонирхсон

2. Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах ажлыг оновчтой зохион байгуулж, олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход уг үзэсгэлэнг үзэж сонирхсон хүмүүсийн тооны нэмэгдсэн байдал:

Бүгд найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан "КОТФА" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, "Хүртээмжтэй аялал жуулчлал" уриан дор зохион байгуулагдсан "ITM-2021" аялал жуулчлалын үзэсгэлэнг 13,800 гаруй хүн үзэж сонирхсон.

Коронавирус /Ковид-19/ цар тахлаас шалтгаалан "Франкфурт", "ФАТА" олон улсын үзэсгэлэнгүүд зохион байгуулагдаагүй болно.

3. Улаанбаатар хотод ирсэн жуулчдын зорин очих газрыг шинээр бий болгож аялал жуулчлалын эргэлтэд оруулсан байдал:

Улаанбаатар хотод ирж буй гадаад, дотоодын жуулчдыг татах, хотын аяллын шинэ бүтээгдэхүүн бий болгох, зорин очих газрыг нэмэгдүүлэх, түүх, соёлын дурсгалыг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор 5 газрыг аялал жуулчлалын эргэлтэд оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Их тэнгэрийн амны хадны зураг
- ✓ Гачууртын амны хадны зураг
- ✓ Туулын Хар түнийн ордны туурь
- ✓ Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолбор
- ✓ Ар гүнтийн дөрвөлжин булшнууд

"Их тэнгэрийн амны хадны зураг" орчмыг тохижуулах ажлын худалдан авах ажиллагааг хамтран зохион байгуулж 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр нээлтээ хийж тендер үнэлэх шатандаа, "Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш" цогцолбор орчмын тохижилт, бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, төсөв боловсруулах ажилд "Батдах" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Нийслэлийн 2022 оны төсвийн төсөлд тусгах

хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний саналд Сонгино-хайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ар гүнт дэх дөрвөлжин булш”, Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Гачууртын амны хадны зураг” орчмын тохижилт, бүтээн байгуулалт, зураг төсвийн саналыг тусган нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Г/. ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

Тайлант хугацаанд нийт 15 өргөдөл, гомдол, хүсэлт буюу 1800-1200 тусгай дугаарын утаснаас 1 санал, 1 гомдол, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаар дамжин ирсэн 13 хүсэлтийг хүлээн авч холбогдох чиг үүргийн хүрээнд шийдвэрлэсэн. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл байхгүй. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 16 цаг 22 минут, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 хоногоор буурсан үзүүлэлттэй ажилласан.

Д/. БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

“Сонгинохайрхан уулын явган аяллын чиглэлийг тэмдэгжүүлэх, амрах цэгүүдийг тохижуулах ажил”, “Их тэнгэрийн амны хадны зургийн орчныг тохижуулах ажил”, “Туул голын эрэг дагуу аялал жуулчлалын дэд бүтцийг байгуулах, зогсоол, гэрэлтүүлэг, хяналтын байр барих” ажлуудын тендерийн ажлыг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран зохион байгуулсан. Үүнд:

“Сонгинохайрхан уулын явган аяллын чиглэлийг тэмдэгжүүлэх, амрах цэгүүдийг тохижуулах ажил”

Тендер шалгаруулалтын төрөл: Ажил
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ/202106393
Санхүүгийн эх үүсвэр: Нийслэлийн төсвийн хөрөнгө
Нийт төсөвт өртөг: 63,183,533

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Сонгинохайрхан уулын явган аяллын чиглэлийг тохижуулах тухай” А/397 дугаар захирамжийн дагуу ажлын зураг, төсөв, архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулж, нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар тендерийн ажлыг зохион байгуулж, “хамгийн сайн” тендерээр шалгарч зөвлөмж ирүүлсэн “Люксландшафт” гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлэн 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүлээж авсан.

“Их тэнгэрийн амны хадны зургийн орчныг тохижуулах ажил”

Тендер шалгаруулалтын төрөл: Ажил
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ/202109534
Санхүүгийн эх үүсвэр: Нийслэлийн төсвийн хөрөнгө
Нийт төсөвт өртөг: 135,909,501

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Их тэнгэрийн амны хадны зургийн орчныг тохижуулах тухай” А/676 дугаар захирамжийн хүрээнд ажлын зураг, төсөв, архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулж, нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар тендерийн ажлыг зохион байгуулж 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр нээлтээ хийж тендер үнэлэх шатандаа байна.

Тендерийн өрсөлдөгчдийн нэр	ХААА/202106393	Өрсөлдөгч	ХААА/202106393	Төлөв	Эмтгэл
1. Хүрээлэн	63,183,533	Салбар	63,183,533	Салбар	Төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөлдөөр байгаа өмчлөлтөд оруулах ажил тухайн тусгай зориулалтын 27 дугаар тусламж 27.4 өс нөхцөл
2. Өвчлэлтэй байр	63,183,533	Салбар	63,183,533	Салбар	Төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөлдөөр байгаа өмчлөлтөд оруулах ажил тухайн тусгай зориулалтын 27 дугаар тусламж 27.4 өс нөхцөл
3. Дэлгэрэнгүй	63,183,533	Салбар	63,183,533	Салбар	Төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөлдөөр байгаа өмчлөлтөд оруулах ажил тухайн тусгай зориулалтын 27 дугаар тусламж 27.4 өс нөхцөл

“Туул голын эрэг дагуу аялал жуулчлалын дэд бүтцийг байгуулах, зогсоол, гэрэлтүүлэг, хяналтын байр барих ажил”

Тендер шалгаруулалтын төрөл: Ажил
Тендер шалгаруулалтын дугаар: ЗТХЯ/22103065
Санхүүгийн эх үүсвэр: Улсын төсөв
Нийт төсөвт өртөг: 250,000,000

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/560 дугаар захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Шинэ гүүрний баруун урд талд 10.5 га нийтийн эзэмшлийн талбайд загвар зураг, ажлын зураг төслийг үе шаттайгаар боловсруулж байна. Тус ажлыг гүйцэтгэх тендерийн шалгаруулалтыг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран 2 удаа зохион байгуулсан боловч шаардлага хангасан тендерийн ажлын материал ирүүлээгүй. Иймд ажлын зураг төслийг нийслэлийн Онцгой байдлын газар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газартай зөвшилцөж ажлын тоо хэмжээ, төсвийг Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвөөс эцэслэн магадлал хийлгэж батлуулахаар шийдвэрлэсэн.

Е/. НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ САНД ОРУУЛСАН ТАЙЛАН МЭДЭЭ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Газрын үйл ажиллагааны тайланд 2021 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөг баталж, бодлогын зорилтын хэрэгжилтийн чиглэлээр 6, тогтоол шийдвэр, удирдлагаас гаргасан шийдвэрийн чиглэлээр 3, дотоод ажилд явуулах хяналтын чиглэлээр 2, хяналт шинжилгээний мөрөөр 1 нийт 12 ажлыг хийхээр төлөвлөсөн.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалаар дүгнэхэд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 43.3%, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай 2021 онд хамтран ажиллах гэрээний 10 арга хэмжээний хэрэгжилт 78%, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 3 дугаар улирлын байдлаар 70% үнэлэгдэв.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын нийт 40 арга хэмжээ тусгагдсан. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалаар дүгнэхэд 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт жилийн эцсийн байдлаар 91.31 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалын дагуу тооцоход:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		
Нийт ажлын тоо		40
1. Бүрэн хэрэгжсэн	100 хувь	23
2. Үр дүн гарсан	90 хувь	6
3. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70 хувь	9
4. Ажил эхэлсэн	50 хувь	-
5. Боловсруулалтын шатанд	30 хувь	-
6. Бэлтгэл ажлыг хангаж байгаа /ажил зохион байгуулаагүй	0 хувь	-
7. Хугацаа болоогүй	-	2
Үнэлгээний хувь		91.31

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан “Хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилтийг хангах төлөвлөгөөнд 11 заалт тусгагдсан. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалаар дүгнэхэд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан “Хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний тайлан жилийн эцсийн байдлаар 94,45 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалын дагуу тооцоход:

“Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан “Хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний биелэлт		
Нийт ажлын тоо		11
1. Бүрэн хэрэгжсэн	100 хувь	6
2. Үр дүн гарсан	90 хувь	5
3. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70 хувь	-
4. Ажил эхэлсэн	50 хувь	-
5. Боловсруулалтын шатанд	30 хувь	-
6. Бэлтгэл ажлыг хангаж байгаа /ажил зохион байгуулаагүй	0 хувь	-
7. Хугацаа болоогүй	-	-
Үнэлгээний хувь		94.45

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 25 зүйл, заалтын хэрэгжилтийг дүгнэхэд, гүйцэтгэл 98.8 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” үр дүнтэй байна.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалын дагуу тооцоход:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төрөл	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн /90-100/	Хэрэгжих шатандаа /50-89/	Хэрэгжилт хангалтгүй /10-49/	Хэрэгжээгүй /0-9/	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн дундаж
Монгол Улсын хууль	2	15	15					100%
Монгол Улсын Засгийн газрын тогтоол	1	9	9					100%
Монгол Улын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	1	1		1				70%
НИЙТ	4	25	24	1				98.8%

- ✓ “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй буюу “бүрэн хэрэгжсэн”,
- ✓ “Төрийн албаны тухай хууль”-ийн хэрэгжилт 100 хувьтай буюу “бүрэн хэрэгжсэн”,
- ✓ “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” тогтоолын хэрэгжилт 100 хувьтай буюу “бүрэн хэрэгжсэн”.
- ✓ Засгийн газрын 14 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 70 хувийн гүйцэтгэлтэй буюу “хэрэгжих шатандаа” байна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, дүрэм, бүтэц, чиг үүргийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, тэдгээрийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүнг https://tourism.ub.gov.mn/ сайтад байршуулж, тухай бүр шинэчилсэн.	100%
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Албан хаагчдын нэр, албан тушаал, харилцах утас, цахим хаяг, байгууллагын мөрдөгдөж байгаа дүрэм журмыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулан ажиллаж байна. Байгууллагын цахим хуудсанд “төрийн үйлчилгээ”-ний цэс нээн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллүүд, Өргөдөл гомдол хүлээн авах асуудал хариуцсан ажилтны холбогдох мэдээллийг байршуулав.	100%
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байрлуулан тухай бүр шинэчлэх	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 120 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах, сунгахад бүрдүүлэх материалын жагсаалтыг байгууллагын цахим хуудасны Төрийн үйлчилгээний цэс болон мэдээллийн самбарт ил тод байршуулсан.	100%
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Аялал жуулчлалын тухай хууль болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам, үйлчилгээний байгууллагуудад мөрдөх стандартыг www.tourism.ub.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	90%
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус	“Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулах ажлын хүрээнд суурь судалгааны маягтыг боловсруулж, судалгааг Монголын Аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллагууд болон байгууллагын	100%

	байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах	цахим хуудаст байршуулан цахимаар авч, арга хэмжээний төслийг 7 зорилтын хүрээнд боловсруулж төсөлд газрын албан хаагчид, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, харьяа агентлагууд, иргэд, олон нийт болон салбарын мэргэжлийн холбоодоос цахимаар саналыг авч нэгтгэсэн. - “Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, холбогдох албан тушаалтан болон байгууллагуудаас санал авч, төрийн ба төрийн бус байгууллага, эрдэмтэн, иргэдийн саналыг авч төсөлд тусгасан.	
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Нийслэл хотод аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлтийг цахим үйлчилгээний нэгдсэн www.e-mongolia.mn сайтаар цахимаар хүлээн авч байна. Стандартын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний хуудсыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэн ажиллаж байна.	100%
7.	Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухай төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх	Тус газрын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа ажил байхгүй.	-
8.	Тухай байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудаснаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 120 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн хүсэлтийн дагуу аж ахуйн нэгжид стандартын үзлэг шалгалт зохион байгуулж, зөвшөөрөл олгосон тухай газрын даргын тушаал, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдийн нэр, оноосон нэр, олгосон болон дуусгавар болох хугацаатай жагсаалтыг тухай бүр байршуулж байна.	100%

9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх	Улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй.	-
Хэсгийн дундаж хувь:			98.5%
Хоёр: Хүний нөөцийн ил тод байдал			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	Тус газрын Захиргааны хэлтсийн даргын сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар Зөвлөлд хүргүүлж, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	100%
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийг баталсан газрын даргын тушаалыг цахим хуудаст байрлуулсан.	100%
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал”-ыг цахим хуудас, мэдээллийн самбартаа байршуулав.	100%
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хянах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	Байгууллагын цахим хуудсанд ил тод байдлыг хангах зорилгоор цэс нээж хүний нөөц цонхонд байгууллагын удирдлага болон албан хаагчдын холбогдох мэдээллийг байршуулан тухай бүр шинэчлэн ажилласан.	100%
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	ЗГХЭГ-аас зохион байгуулсан “ Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалтад газрын 18 албан хаагч хамрагдаж төрийн жинхэнэ албан хаагчийн төлөвлөгөө боловсруулах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааны мэдлэг мэдээллийг авч шалгалт өгч гэрчилгээ авсан.	90%

	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын хүрээнд Газрын даргын тушаалаар албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний баг байгуулан ажиллаж, үнэлж байна.	
Хэсгийн дундаж хувь:		98.0%
Хэрэгжилтийн дундаж хувь: 98.25		

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

А/. Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр:

Салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах замаар бизнесийн таатай, эрүүл орчинг бүрдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын баримт бичиг төсөл, хөтөлбөрүүдийг хамтран тодорхойлох, гадаад харилцааг өргөжүүлэх, хөгжүүлэх, бусад олон талт ажлуудыг зохион байгуулах чиглэлээр гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай байгуулсан 23 хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Улаанбаатар-2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, “Нийслэлийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээний төсөл”, “Ковидын дараах нийслэлийн Аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл боловсруулах, Улаанбаатар хотод ирж буй гадаад, дотоодын жуулчдыг татах, хотын аяллын шинэ бүтээгдэхүүн бий болгох, зорин очих газрыг нэмэгдүүлэх, зочид буудал, дэн буудлуудын үйлчилгээний чанар, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах, зочлох үйлчилгээний салбарын эрхлэгч, менежер, ажилтнууд, жуулчидтай шууд харилцдаг төрийн байгууллагын ажилтнуудад зориулж үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдал, харилцааны соёл, хөтөч-тайлбарлагчийн зэрэг сургалтуудыг зохион байгуулах болон тус газраас жуулчдад зориулсан аялал жуулчлал, спорт, соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулахад нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажилласан.

Б/. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажлын талаар:

“Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”, халдварын тархалтын “Улбар шар түвшин”-д шилжүүлсэн хугацаанд “Хариуцлагын гэрээ” байгуулан ажиллаж байгаа үйлчилгээний газрууд болон үйл ажиллагаа нь хязгаарлагдаагүй худалдаа, үйлчилгээний газруудад халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд түр журам зөрчсөн тухай холбогдох байгууллагын санал хүсэлтээр 7 аж ахуйн нэгжид Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулж, сануулах арга хэмжээ авч ажилласан.


Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр иргэдийн төлөөлөлтэй уулзалт хийж, газрын чиг үүргийн хүрээнд хүсэлт гаргасан Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны иргэн М.Болормаагийн хүсэлтийн дагуу Хан-Уул дүүргийн Богдхан уулын Зайсан-Баруун ширээтийн аяллын замын тохижилт, 4 хайрханы тохижилтын ажлын талаар болон цаашид хийгдэх тохижилтын ажлын талаар мэдээлэл танилцуулсан.

В/. Шинээр санаачилсан ажлууд:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.8 дахь заалт-“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ, Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын 4.3.8 дахь заалт-Олон нийтийн сүлжээнд суурилсан цахим сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.2.1 дэх заалт-Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад, дотоодод түгээн цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ. гэж заасан зорилтыг хүрээнд дараах ажлуудыг санаачлан зохион байгууллаа. Үүнд:

Тус газраас эвент арга хэмжээнүүдийг цахимаар зохион байгуулж, 8 контент бэлтгэн телевиз, сайт, олон нийтийн сүлжээгээр дамжуулан 2,511,383 хүнд хүргэсэн байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 2022 онд зохион байгуулах эвент арга хэмжээний контент бэлтгэж үзэсгэлэн, арга хэмжээ болон цахимаар олон нийтэд сурталчилсан.



- ✓ Тогтмол зохион байгуулдаг эвент арга хэмжээ, үзэсгэлэнгийн төсвийг нэгдсэн жагсаалтаар батлах, эсхүл байгууллагын төсөвт суулган батлах

ТАНИЛЦСАН
ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Х.СОДНОМДЭМБЭРЭЛ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛЖ НЭГТГЭСЭН:

ЖУУЛЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ